

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/254/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭСАНТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК
захирал: С.Оюунгэрэл

Утас: 70117179 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.01.25 № 01/01.
танай _____ -ны № _____ -г

**ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭСАНТ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
О.АНХНЫБАЯР ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 237,945.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

019000131

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 81,49 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	213,084,909.21	338,280,616.84
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	126,196,569.82	237,945,817.45
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	126,196,569.82	237,945,817.45
3121	Төгрөг	126,196,569.82	237,945,817.45
31211	Төрийн сангийн харилцах	126,196,569.82	237,945,817.45
35	БАРАА МАТЕРИАЛ	86,888,339.39	100,334,799.39
351	Түүхий эд материал	67,179,485.89	73,365,445.89
35110	Тусгай зориулалттай материал	66,609,485.89	73,163,445.89
35130	Эм боох материал	570,000.00	202,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	00.00	225,000.00
354	Хангамжийн материал	19,708,853.50	26,744,353.50
35460	Хүнсний материал	16,900.00	1,751,400.00
35470	Бусад хангамжийн материал	19,691,953.50	24,992,953.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,048,716,425.16	3,413,025,773.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,048,716,425.16	3,413,025,773.62
392	Биет хөрөнгө	3,004,624,425.32	3,368,933,773.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,046,977,096.60	3,233,399,496.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	-266,267,485.44	(316,853,676.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	251,016,406.80	391,249,706.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(125,322,248.29)	(152,176,789.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	124,689,964.36	239,007,064.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,952,421.71)	(34,175,140.90)
39214	Бусад үндсэн хөрөнгө	456,860.00	456,860.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(42,180.00)	(42,180.00)
39217	Ном	8,068,433.00	8,068,433.00
393	Биет бус хөрөнгө	44,091,999.84	44,091,999.84
39301	Програм хангамж	1,370,000.00	1,370,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,356,000.16)	(1,356,000.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	44,078,000.00	44,078,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,261,801,334.37	3,751,306,390.46
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,261,801,334.37	3,751,306,390.46
51	Засгийн газрын хувь оролцоо	3,261,801,334.37	3,751,306,390.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	544,201,863.95	544,201,863.95
51101	Өмч: - төрийн	544,201,863.95	544,201,863.95
512	Хуримтлагдсан үр дүн	2,049,453,044.42	2,538,958,100.51
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,212,348,289.95)	(1,212,348,289.95)
51220	Тайлант үеийн үр дүн	3,261,801,334.37	3,751,306,390.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	668,146,426.00	668,146,426.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,261,801,334.37	3,751,306,390.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,446,535,152.06	2,875,701,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,285,131,652.06	2,875,701,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,159,668,881.06	408,664,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,072,829,291.67	401,726,350.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,072,829,291.67	401,726,350.00
122001	Хандив тусламж /дотоод/	86,839,589.39	6,937,950.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	2,125,462,771.00	2,467,037,100.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,730,321,371.00	2,109,389,400.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	395,141,400.00	357,647,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	161,403,500.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	161,403,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	161,403,500.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,184,733,817.69	2,379,614,360.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,184,733,817.69	2,377,131,694.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,891,323,483.38	2,263,225,519.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,184,705,003.67	1,446,999,157.66
210101	Үндсэн цалин	817,712,695.48	957,714,433.39
210102	Нэмэгдэл	285,573,811.31	410,628,655.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,722,610.09
210104	Урамшуулал	81,418,496.88	76,933,458.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,927,691.20	171,581,051.91
210201	Тэтгэврийн даатгал	98,111,913.10	123,908,970.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,833,961.30	12,936,418.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,860,448.62	9,461,231.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,920,124.35	690,184.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,201,243.83	24,584,248.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	310,663,200.00	356,631,522.18
210301	Гэрэл, цахилгаан	9,752,800.00	11,179,162.18
210302	Түлш, халаалт	298,110,400.00	342,350,360.00
210303	Цэвэр, бохир ус	2,800,000.00	3,102,000.00
2105	Нормативт зардал	102,348,500.00	125,297,700.00
210502	Хоол, хүнс	102,348,500.00	125,297,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,010,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,010,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,738,000.00	12,368,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,763,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,975,000.00	12,368,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	140,931,088.51	149,347,687.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,821,780.00	59,867,238.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,118,942.00	7,240,748.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,990,366.51	82,239,701.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	293,410,334.31	113,906,174.62

2132	Бусад урсгал шилжүүлэг	293,079,162.00	113,889,996.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	100,675,800.00	97,902,096.80
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,940,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	97,462,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,999,862.00	15,987,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	331,172.31	16,177.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	331,172.31	16,177.82
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	2,482,666.63
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	2,482,666.63
224001	Стратегийн нөөц хөрөнгө	00.00	2,482,666.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,261,801,334.37	496,087,039.14
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	6,581,983.05
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	6,581,983.05
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-6,581,983.05
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,261,801,334.37	489,505,056.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,286,866,271.00	2,467,037,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,125,462,771.00	2,467,037,100.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	2,125,462,771.00	2,467,037,100.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,730,321,371.00	2,109,389,400.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	395,141,400.00	357,647,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	161,403,500.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	161,403,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	161,403,500.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,160,669,701.18	2,355,287,852.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,160,669,701.18	2,355,287,852.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,867,259,276.87	2,241,276,677.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,184,716,003.67	1,446,999,147.57
210101	Үндсэн цалин	817,460,260.78	957,714,433.39
210102	Нэмэгдэл	285,827,246.01	410,628,655.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,722,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,927,601.20	171,581,062.00
210201	Тэтгэврийн даатгал	98,111,823.04	123,908,970.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,833,961.18	12,936,418.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,860,448.62	9,461,231.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,920,124.41	690,204.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,201,243.95	24,584,239.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	310,663,200.00	356,631,522.18
210301	Гэрэл, цахилгаан	9,752,800.00	11,179,162.18
210302	Түлш, халаалт	298,110,400.00	342,350,360.00
210303	Цэвэр, бохир ус	2,800,000.00	3,102,000.00
2105	Нормативт зардал	102,340,200.00	125,671,700.00
210502	Хоол, хүнс	102,340,200.00	125,671,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,430,600.00	12,206,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,763,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,667,600.00	12,206,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,181,672.00	127,187,246.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,264,503.00	110,111,376.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,917,169.00	17,075,870.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	293,410,424.31	114,011,174.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	293,079,252.00	113,994,996.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	100,675,800.00	98,127,096.80
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,940,800.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	97,462,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,999,952.00	15,867,900.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	331,172.31	16,177.82
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	331,172.31	16,177.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	126,196,569.82	111,749,247.63
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	126,196,569.82	111,749,247.63
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	126,196,569.82
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	126,196,569.82	237,945,817.45

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /			
		Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	500,123,863.95	312,843,169.47	(55,065,822.27)	757,901,211.15
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,320,591.46	1,320,591.46

C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	500,123,863.95	312,843,169.47	(53,745,230.81)	759,221,802.61
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	(1,320,591.46)	00.00	(1,320,591.46)
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,553,941,028.10	1,553,941,028.10
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	544,201,863.95	668,146,426.00	2,049,453,044.42	3,261,801,334.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	544,201,863.95	668,146,426.00	2,049,453,044.42	3,261,801,334.37
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	489,505,056.09	489,505,056.09
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	544,201,863.95	668,146,426.00	2,538,958,100.51	3,751,306,390.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	126,196,569.82	(126,196,569.82)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,593,232,700.00	2,247,687,428.55	345,545,271.45	86.68
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,593,232,700.00	2,247,687,428.55	345,545,271.45	86.68
210	Бараа, үйлчилгээний зардал	2,456,448,400.00	2,133,692,431.75	322,755,968.25	86.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,621,613,700.00	1,446,999,147.57	174,614,552.43	89.23
210101	Үндсэн цалин	1,086,022,900.00	957,714,433.39	128,308,466.61	88.19
210102	Нэмэгдэл	452,021,400.00	410,628,655.31	41,392,744.69	90.84
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	-	1,722,600.00	(1,722,600.00)	-
210104	Урамшуулал	83,569,400.00	76,933,458.87	6,635,941.13	92.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	202,701,800.00	171,581,062.00	31,120,738.00	84.65
210201	Тэтгэврийн даатгал	137,837,200.00	123,908,970.00	13,928,230.00	89.90
210202	Тэтгэмжийн даатгал	16,216,200.00	12,936,418.00	3,279,782.00	79.77
210203	ҮОМШӨ ний даатгал	12,972,900.00	9,461,231.00	3,511,669.00	72.93
210204	Ажилгүйдлийн даатгал	3,243,300.00	690,204.00	2,553,096.00	21.28
210205	Эрүүл мэндийн даатгал	32,432,200.00	24,584,239.00	7,847,961.00	75.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	356,647,700.00	356,631,522.18	16,177.82	100.00
210301	Гэрэл цахилгаан	10,872,800.00	11,179,162.18	(306,362.18)	102.82
210302	Түлш, халаалт	342,274,900.00	342,350,360.00	(75,460.00)	100.02
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	3,102,000.00	398,000.00	88.63
2105	Нормативт зардал	132,139,400.00	125,671,700.00	6,467,700.00	95.11
210502	Хоол, хүнс	132,139,400.00	125,671,700.00	6,467,700.00	95.11
2106	Эд хогшил худалдан авах	1,000,000.00	1,000,000.00	-	100.00

210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	12,206,000.00	12,206,000.00	-	100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	12,206,000.00	12,206,000.00	-	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	130,139,800.00	19,603,000.00	110,536,800.00	15.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,830,800.00	2,527,130.00	109,303,670.00	2.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,309,000.00	17,075,870.00	1,233,130.00	93.26
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,784,300.00	113,994,996.80	22,789,303.20	83.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	136,784,300.00	113,994,996.80	22,789,303.20	83.34
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	120,916,400.00	98,127,096.80	22,789,303.20	81.15
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	15,867,900.00	15,867,900.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	126,196,569.82	(126,196,569.82)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	237,945,817.45	(237,945,817.45)	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургууль нь Монгол Улсын боловсролын ерөнхий хуулийн дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулдаг. 2023-2024 оны хичээлийн жилд хамтын оролцоонд суурилсан сургуулийн менежментийг сайжруулах жил болгон үйл ажиллагаа зохион байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд сургуулийн үйл ажиллагаанд нэгдсэн дүгнэлт хийж сургалтын чанарыг сайжруулахыг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

Алсын хараа

Асуудлыг шинжлэх ухаанч арга барилаар шийдвэрлэдэг, Өөрийгөө тасралтгүй хөгжүүлдэг иргэнийг бэлтгэх

Зорилт

- ✓ Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, тухай хуулийг сургалтын байгууллага бүрийн багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийтэд сурталчлан таниулах, тэдний оролцоотой үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор "Хуулиа хэрэгжүүлье" аяныг зохион байгуулах
- ✓ Малчин болон алслагдсан бүс нутагт амьдарч байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургалт, үйл ажиллагаагаар дэмжих, сургуульд элсэн суралцсан 6 настанд дасан зохицох бэлтгэл хангах
- ✓ Тэгш хүртээмжтэй, тэгш боломж олгосон, хамтын хариуцлагатай байх суурь зарчимд тулгуурлан байршлаас хамаарсан үйлчилгээний чанарын ялгааг бууруулж хүүхэд бүр гэртээ ойр байрлах цэцэрлэг, сургуульд хамрагдах хүсэл, эрмэлзлийг нэмэгдүүлэх
- ✓ Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах
- ✓ Суралцагчийн математик, англи хэлний сургалтыг дэмжих цахим технологи (сургалтын платформ)-д суурилсан нэмэлт хөтөлбөрийг бага, суурь боловсролын зарим ангид хэрэгжүүлж, суралцагчийн ур чадвар багшийн арга зүйд ахиц гаргах
- ✓ Суралцагчдын шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшүүлэх нэгдмэл агуулга бүхий төсөлт ажлыг анги, бүлгээс үл хамааран багаар хамтран гүйцэтгүүлж үр дүнг хагас жил бүр тооцох
- ✓ Суралцахуй болон судлагдахуунд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагааг дэмжиж, ажлын гүйцэтгэл, үр дүнд шинжилгээ хийх, багшийн мэргэжлийн хөгжлийн үндэсний цахим системийг ашиглах замаар багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх ур чадварт гарсан ахиц, өөрчлөлт, үр дүнг тооцох
- ✓ Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах, тэгш боломж олгох орчныг сургалтын байгууллага бүр төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн дэмжлэгтэйгээр бүрдүүлж, дэмжлэгийн багийн үйл ажиллагааг сайжруулах замаар тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх

- ✓ Мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн суралцагч бүрийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран MEDLE.mn сургалтын үндэсний нэгдсэн платформыг ашиглан суралцах тэгш боломж бүрдүүлэх
- ✓ Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагын дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Эрдэнэсант сумын сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Сургууль нь сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, мэдлэг чадвар авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг эх асран хамгаалагч, дэмжигчтэй хамтран ажиллах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Боловсролын ерөнхий хууль шинэчилсэн найруулга
- ✓ Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль
- ✓ Зөвшөөрлийн тухай хууль
- ✓ Багшийн хөгжлийг дэмжих тухай
- ✓ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамрах албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор цалингийн доод хэмжээг тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу бүрэн ирүүлсэн.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,195.2 мянган төгрөгөөр буюу 1859 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	126,196.6	237,945.8	111,749.2
Бараа материал	86,888.3	100,334.8	13,446.5
Үндсэн хөрөнгө	3,048,716.4	3,413,025.8	364,309.4
Нийт хөрөнгө	3,261,801.3	3,751,306.4	489,505.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,261,801.3	3,751,303.4	489,505.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,261,801.3	3,751,303.4	489,505.1

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна. Үүнд:

Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 111,749.2 мянган төгрөгөөр өссөн байгаа нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

Бараа материал өмнөх оноос 13,446.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 279,752.7 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 266,306.2 мянган төгрөгийн

бараа материалыг зарцуулан хичээл дадлагын хэрэглэгдхүүн үлдэгдэлтэй байгаа нь гол нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 364,309.4 мянган төгрөгөөр өссөн нь сургуулийн 100 жилийн ойн хүрээнд төсвийн хөрөнгөөр 241,172.8 мянган төгрөг, хандиваар 214,440.9 мянган төгрөг нийт 455,613.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 14,640.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актласан, 76,663.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,516,774.0 мянган төгрөг, нийт зарлагыг 2,516,774.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 281,189.0 мянган төгрөгөөр бууруулж, зардлыг 2,235,585.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төв аймгийн Эрдэнэсант сумын ерөнхий боловсролын сургуулийн төсвийн захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 357,647.7 мянган төгрөгөөр нэмж тодотгосон байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,890,055.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 357,631.5 мянган төгрөгийн санхүүжилт авч ажилласан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,247,687.4 мянган төгрөг буюу 86,7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80227-байр ашиглах үйлчилгээ	4,882.4	4,871.8	10.6	99.8
2	80321-сургалт семинар	2,441.2	2,441.2		
3	81605-эрүүл мэндийг дэмжих	4,882.4	3,460.0	1,422.4	70.9
4	81801-үдийн цай хөтөлбөр	120,916.4	98,127.1	22,789.3	81.2
5	81806-дотуур байрны үйлчилгээ	192,926.0	173,448.2	19,477.8	89.9
6	81816-хүүхдэд ээлтэй сургалтын орчин	56,740.7	55,308.6	1,432.1	97.5
7	81823-боловсролын байгууллагын багш,	10,985.4	10,985.0	0.4	99.9

	ажилтны мэргэжил дээшлүүлэх				
8	81827-бичиг үсгийн боловсрол хөтөлбөр	5,635.0	3,769.9	1,865.1	66.9
9	81834-боловсролын стандарт% сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,424,648.6	1,201,892.3	222,756.3	84.4
10	81835-сургалтын хэвийн үйл ажиллагаа	406,830.4	331,055.2	75,775.2	81.4
11	81844-гүнзгий болон төрөлжсөн	4,696.5	4,696.5		
	дүн	2,235,585.0	1,890,055.9	345,529.1	84.5
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
12	80111-төрийн өмчит барилгын тогтмол зардал	357,647.7	356,631.5	1,016.2	99.7
	дүн	357,647.7	356,631.5	1,016.2	99.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь худалдан авах ажиллагаагаар бараа үйлчилгээ худалдан авалт хийхдээ хоол хүнсний зардалд 125,297.7 мянган төгрөг, норматив зардал 59,867.2 төгрөгийн худалдан авалт хийхдээ Засаг даргын тамгын газраас нэгдсэн журмаар тендер сонгон шалгаруулалт хийдэг, нэгдсэн гэрээтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Я.Оюун, Шинжээч Х.Ариунжаргал, Ц.Цацрал нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 6,647,344.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 99,710.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 74,782.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчин ажиллаж урамшуулалт цалинг 6,635.9 мянган төгрөг, хоол хүнсийг 6,467.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 109,303.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн. Хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа хэдий ч байгалийн давагдашгүй хүчн зүйл, цас зудын хүндрэлтэй үед хэмнэлтийн хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

4.4.1.1 Тайлант хугацаанд шилэн дансанд нийт 159 мэдээ мэдээллээс 142 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, хугацаа хоцорсон 10 мэдээлэл байршуулсан, 7 мэдээлэл байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй 172,941.2 мянган төгрөгийн гүйлгээг оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь. МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээнд дээр хөрөнгийн хэмжээ 333,813.3 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 544,201.8 мянган төгрөг засгийн газрын оролцоо сан 223,659.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь хөрөнгө өр төлбөр болон өмчийн хувь оролцоог зөв дүнгээр тусгасан ба үнэлгээ болон хуваарилалтын залруулга, холбогдох тодруулгыг зохих ёсоор хэмжсэн тайлбарласан байх “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийг үнэн зөв баталгаажуулах, бүртгэлдээ өөрчлөлт хийх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2.2 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 61,490.2 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн, гэрээгүй баримтжуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “ холбогдох олон улсын стандарт , эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь. МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”; 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, Засгийн газар оролцоо сангийн бүртгэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг

хөтлөлт, өглөгийн данстай холбоотой нийт 7 зөвлөмж хүргүүлснээс 4 зөвлөмж хэрэгжүүлэн ажилласан, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 80,606.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	1,793.0	1	1,793.0	100.0
Зөвлөмж	2	78,813.5	1	700.0	0.9
Нийт дүн	3	80,606.5	3	2,493.0	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал төсөв, санхүүжилтийг үндэслэлтэй баталдаг байх, шинэчлэлийн бодлого, төрийн чиг үүргийг хангалттай хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар анхаарал хандуулах болно. Сургуулийн газар эзэмших эрхтэй холбоотой асуудлыг хянаж үзэх, газрын ашиглалт, баталгаажуулалт, сайжруулалт, төлбөр төлөлтийн талаар, үр дүнгийн урамшууллын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,230.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 3,230.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

5.2 Албан шаардлага

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны Цахим баримтын бүрдэлд 3,120.0 мянган төгрөгийн гүйлгээ дутуу бүртгэсэн байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг хэрэгжүүлж ажиллах гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим баримтын бүрдэлгүй гүйлгээ гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

5.3.2 Бичиг хэрэг хөтлөлтийн талаар

Илрүүлэлт: Тус байгууллага нь бичиг хэрэг хөтлөлт, дээд газраас ирсэн бичиг, албан тоотууд, тушаал шийдвэрүүд нь баримт бичиг бүртгэл, хүлээн авах, явуулах журам, архивд шилжүүлэх ажил нь зохион байгуулалтгүй баримт бичгийг боловсруулах, ангилах, баталгаажуулах, хэрэг болгон бүрдүүлэх, ач холбогдлыг нь үнэлэн тогтоогоогүй байгаа нь бичиг хэргийн стандарт, архивын дүрэм журамтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Албан хөрөнгө хөтлөлтийн стандартыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материал худалдан авах анхан шатны баримт дутуу бүртгэгдсэн..	1	3,230.0					1	3,230.0				
Дүн	2	3,230.0					1	3,230.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
159 мэдээллээс 142 мэдээллийг хугацаанд нь, хугацаа хоцорсон 10 мэдээлэл байршуулж 7 мэдээлэл байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээллийг мэдээлээгүй	1	172,941.2					1	172,941.2
Дүн	1	172,941.2					1	172,941.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Улсын хөрөнгийн хэмжээ 333,813.3 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 544,201.9 мянган төгрөг засгийн газрын оролцоо 210,388.6 мянган	1	210,388.6						1 210,388.6

төгрөгөөр зөрүүтэй байна.							
Цахим баримтын бүрдэлд 61,490.2 мянган төгрөгийн баримт илүү бүртгэгдсэн	1	61,490.2			1	61,490.2	
Дүн	2	271,878.8			2	61,490.2	1 210,388.6
Нийт дүн	3	444,820.0			2	234,431.4	1 210,388.6



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 45-14570516-ТӨА-2024/

Зуунмод

257/НА-СТА-МЛЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхан шатны цахим баримт 61,490,200 /жаран нэгэн сая дөрвөн зуун ерэн мянга хоёр зуун/ төгрөгөөр илүү бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040604

2. Цаашид алдаа², зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал О.Анхныбаяр, нягтлан бодогч Н.Сумъяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/



²Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 46-14570516-ТӨА-2024/

Зуунмод

1257/НА-СТА-ТМБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 172,941,200 /нэг зуун далан хоёр сая есөн зуун дөчин нэгэн мянга хоёр зуун/ төгрөг өссөн дүнгээр дутуу мэдээлсэн, хугацаа хоцорсон 10 мэдээлэл, 7 мэдээлэл байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.4."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд ил тод, бүрэн байршуулах зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт³ ирүүлэх;

³Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



2. Цаашид алдаа⁴, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэсант сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал О.Анхныбаяр, нягтлан бодогч Н.Сумъяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/

⁴Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn